



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/143

Булган сум

Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах  
зардлын хуваарь батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал”-ын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг хууль, журмын дагуу зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Худалдан авах ажиллагааны газар (Б.Баярцэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.

3. “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал”-ын зөвлөх үйлчилгээний ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу тухай бүр нь аймгийн орон нутгийн төсвийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ТҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

**6325010351**



02  
А/143  
Аймгийн Засаг даргын 2025 оны  
дугаар сарын 28-ны/ний өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээ,  
ажлын зураг төсөв боловсруулах зардлын хуваарь

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Зураг төсөл боловсруулах зардал	Тайлбар: Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 108 тоот тушаалаар баталсан "зураг төслийн ажлын жишиг үнэ" /БД 81-16-20/-ийг үндэслэл болгов
1	2	3	4
Бодлогын баримт бичиг			
1	Булган сумын төвийн хэсэгт Ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэх	150,000,000.0	Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дах хэсэг. Аймгийн төвийн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2022 онд батлагдсан бөгөөд дэд бүсэд өртсөн байршлуудад хэсэгчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх шаардлагатай. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024.07.31-ны өдрийн 24/1102024/0513 тоот магадлал, Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 001/шхт2024/0403 тоот тогтоол. Булган сумын төвийн хэсэгт авто замын улаан шугамд нөлөөлөлд өртөж буй газар эзэмшигчийн газрыг худалдаж авах хөрөнгө байхгүй. (Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, үүнтэй уялдуулан төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ. МУЗГ- ҮАХ 4.2.4.1.)
2	Булган хотын гэр хорооллыг тэлэх ерөнхий төлөвлөгөө	80,000,000.0	Булган сумын өмчлөлийн газрын тэлж хөгжих, нөөц газрын бүсчлэл дууссан.
Хэсгийн дүн		230,000,000.0	
Барилга			
3	Булган сумын 1 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга /нэг маягийн ажлын зураг холбоно/	100,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
4	Булган сумын 2 дугаар сургуулийн спорт заалны шинэ барилга	35,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.



5	Булган сумын Төв халуун усны өргөтгөлийн барилга	65,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
6	Хишиг-Өндөр сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга	60,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
7	Булган сумын 2 дугаар багт ахмад, хүүхэд залуучуудын хөгжлийн төв	46,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
8	Булган сумын 9 дугаар УДДТ-ын барилга, гадна шугамын зураг төсөл боловсруулах	110,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
9	Аймгийн хэмжээнд нэг маягийн жишиг халуун усны зураг төсөв	20,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
10	Аймгийн нөөцийн өвс тэжээлийн саравч, байрны зураг төсөв боловсруулах	15,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
11	Хутаг-Өндөр сумын төвийн соёл, спорт заалны зураг төсөв холболт	30,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан.
12	Онцгой байдлын газарт 9 давхар барилгын гал унтраах авто машины гражийн барилгын зураг төсөв боловсруулах.	16,000,000.0	Булган суманд 5 - 10 давхар хүртэл олон давхар барилга баригдаж байгаатай холбогдуулан аймгийн Онцгой байдлын газраас ОБЕГ-т 9 давхар хүртэл барилгын гал унтраах авто машин хүсэлт хүргүүлсэн.
Хэсгийн дүн		497,000,000.0	
Инженерийн дэд бүтэц			
13	Булган сумын төвийн дулаан хангамжийн 1 дугаар контурын шугам, хоолойн гидравлик тооцоо хийлгэх.	40,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн тохируулга нь хот суурин газрын орон сууц, нийгэм ахуйн болон үйлдвэрийн газрын дулааны хэрэглэгч тус бүрийн тооцоот дулааны болон гидравлик горимыг тогтворжуулах, бүх хэрэглэгчийг дулаанаар хэвийн жигд найдвартай хангахын тулд системийн тоноглолын элемент бүрд техникийн болон зохион байгуулалтын иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилготой юм. (Үр дүнд гидравлик тооцоог хийснээр ус дамжуулах төвийн гол шугам хоолойн эдийн



			засгийн ашигтай диаметрийг сонгоход хамгийн их зарцуулгын үед уг хоолойгоор өнгөрөх урсгалын хурд балансад бариулж шаардлагатай түрэлтийн хэмжээг тооцон гаргана.)
14	Булган аймгийн үйлдвэр технологийн паркийн суурь судалгаа, инженерийн дэд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах	200,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Булган аймгийн үйлдвэр технологийн паркийн суурь судалгаа, инженерийн дэд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлыг суурь судалгаа, ажлын зураг гэсэн 2 үе шаттайгаар 7 чиглэлээр судалгаа, төлөвлөлтийн ажил гүйцэтгэнэ.
15	Булган сумын 5-р багийн айл өрх албан байгууллагуудад хэрэгцээний халуун усны дотор гадна, шугам, дулааны шугамын өргөтгөл хийх	30,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. (үр дүнд 9, 10, 11, 19, 20-р байрны дотор систем, 211, 209-р байрны гадна системийн ажлын зураг төслийг гүйцэтгэснээр 111 айлын хэрэгцээний халуун усны шугамын зурагтай болно) Цаашид хэрэгцээний халуу усанд холбогдоогүй орон сууцны барилга байхгүй болно.
16	Сэлэнгэ сумын нархан цэцэрлэгийн өргөтгөл, цаг уурын өртөөний шинэ барилгын гадна дулаан цэвэр усны шугам.	20,000,000.0	2024 онд Сэлэнгэ суманд цаг уурын өртөөний барилгын хөрөнгийн асуудлыг БОАЖСайдын багцаас 250.0 сая төгрөгийн хөрөнгийг орон нутагт эрх шилжүүлж, орон нутаг гадна шугамын асуудлыг шийдвэрлэх үүрэг хүлээн ажлын зураг төсвийг боловсруулсан. Булган аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв "Уран үзэг" ХХК-тай байгуулсан 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 2024/14 тоот гэрээг санхүүжүүлэх зардал.
17	Булган сумын 1 дүгээр баг Майдар голын авто замын гүүр	30,000,000.0	Булган сумын 1 дугаар баг Дашчойнхорлон хийдийн урд талын Майдар голын авто замын гүүрний ажлын зураг төсөв боловсруулах
18	Булган сумын 5 дугаар багийн Д.Дамба-1 гудамж дагуух авто замын зураг төсөв боловсруулах	40,000,000.0	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. Орон сууцны хорооллын гол авто замын төлөвлөлт.
19	Рашаант сумын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг төсөв боловсруулах	60,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал хүрэлцэхгүй болсон.
20	Бугат сумын төвийн Бугат голын авто замын гүүрний зураг төсөв боловсруулах.	20,000,000.0	Бугат сумын төвийн Бугат голын жил болгон үерлэсний улмаас голын түр байгууламж эвдэрч хүндрэлтэй нөхцөл байдал бүрддэг.



21	Гурванбулаг сумын төвийн цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын зураг төсөв боловсруулах	60,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Гурванбулаг сумын төвийн цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төсөв боловсруулах.
Хэсгийн дүн		500,000,000.0	
Их засвар.			
22	АЗДТГ-ын конторын барилгын дотор засварын ажил.	20,000,000.0	Бүтэц шинэчлэгдсэнтэй холбоотойгоор технологийн байгуулалт хийх шаардлагатай болсон. 8 жил дотор засвар хийгдээгүй.
23	Сэлэнгэ сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засварын зураг төсөв	20,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан
24	Усан спорт сургалтын төвийн их засвар	20,000,000.0	Улсын байцаагчийн дүгнэлттэй. Фитнес заалны өргөтгөл, бассейны гадна, дотор засвар, агаарын хоолой, салхивчны системийг өөрчлөх шаардлагатай.
Хэсгийн дүн		60,000,000.0	
Тохижилт, гэрэлтүүлэг			
25	Булган сумын 3-р багийн гэр хорооллын туслах замын зураг төсөв боловсруулах	20,000,000.0	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. Туслах гудамжны 2-р зэрэглэлийн авто зам.
26	Булган сумын Хатанбаатар С.Магсаржавын гудамж дагуух гэрэлтүүлгийг шинэчилж гоёлын гэрэлтүүлэгтэй болгох.	50,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Булган аймгийн 90 жилийг угтсан бүтээлч ажлын хүрээнд аймгийн төвийн Хатанбаатар С.Магсаржавын 1, 2, 3-р гудамж дагуух 1.5 км авто замын хуучин гэрэлтүүлгийг шаардлагатай байршлуудад шилжүүлж стандартад нийцсэн гоёлын гэрэлтүүлгийн зураг боловсруулах.
27	Булган сумын хүүхдийн тоглоомын талбай зураг төсөл боловсруулах	20,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан
28	Ногоон хэв маяг бий болгох зорилгоор цахилгаан авто машин цэнэглэх станц бүхий авто зогсоолын нэг маягийн зураг төсөв боловсруулах	16,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Зам тээврийн сайдаас ирсэн чиглэлийн дагуу Булган аймаг хэрэгжилтийг хангуулахаар үүрэг хүлээсэн.
Хэсгийн дүн		106,000,000.0	



Инженер геологи, дэвсгэр зураг, паспортжуулах, бусад зардал.			
29	Барилга байгууламжийн төлөв байдалд нарийвчилсан үзлэг хийх.	30,000,000.0	Аймгийн Засаг даргын "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Аймгийн инженерийн хийцтэй нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжуудад үнэлгээ хийнэ.
30	Булган сумын 6-р багийн Залуус хэсгийн "Ачуут" гол дагуу эргийн бэхэлгээ, гидрогеологийн судалгааны зураг төсөл боловсруулах	65,000,000.0	Аймгийн онцгой комиссын 2024 оны 09 дугаар сарын 11-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийн 4.1-д тусгагдаж зураг төсөв боловсруулахыг үүрэг болгосон.
31	2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний инженер геологийн зардал	50,000,000.0	11 барилга байгууламжийн ажлын зургийн өмнөх инженер геологийн судалгаа (Ажлын зураг төсөв чанартай болно хурдан хугацаанд зураг төсөв бэлэн болно.)
32	Бугат сумын төвийн авто замын төсөв шинэчилж, салгах зардал	2,000,000.0	Хуучин төсөв шинэчилж салгах зардал
33	Булган аймаг дахь Цагдаагийн газрын шинэ барилгын инженер геологи, геодези, техникийн нөхцөлийн аймгийн оролцооны хөрөнгө	17,000,000.0	ЦЕГ-ын аймгуудад баригдах нэг маягийн цагдаагийн барилгын ажлын зураг төсөв
34	2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 1:1000 масштабтай геодези, дэвсгэр зураг боловсруулах зардал	8,000,000.0	Барилга байгууламжийн ажлын зургийн өмнөх геодезийн судалгаа (Ажлын зураг төсөв чанартай болно хурдан хугацаанд зураг төсөв бэлэн болно.)
35	Онц хэрэгцээ шаардлагатай ажлын зураг төсөв шинэчлэх зардал	15,000,000.0	2026 онд хэрэгжүүлэх Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай ажлын зураг төвийг шинэчлэх хөрөнгө.
36	Онц хэрэгцээ шаардлагатай ажлын зураг төсөв боловсруулах зардал	42,500,000.0	2026 онд хэрэгжүүлэх Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай ажлын зураг төвийг боловсруулах хөрөнгө.
37	2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний техникийн нөхцөлийн зардал	5,000,000.0	10 барилга байгууламжийн ажлын зургийн өмнөх инженер геологийн судалгаа (Ажлын зураг төсөв чанартай болно хурдан хугацаанд зураг төсөв бэлэн болно.)
Хэсгийн дүн		234,500,000.0	



2024 оноос шилжих зураг төслийн санхүүжилт			
38	“Махны үйлдвэрийн цогцолбор”-ын барилга, байгууламжийн ТЭЗҮ, ажлын зураг төсөв боловсруулах.	29,500,000.0	Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дугаар сарын 17-ний өдрийн А/628 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжилт.
39	Булган сумын төв халуун усны барилгын засвар	19,000,000.0	Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн А/703 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал. Их засвар хийх Улсын байцаагчийн дүгнэлт гарсан.
40	Орхон аймгаас Сэлэнгэ сумын төв хүртэлх авто замын дунд шатны зураг төсөв боловсруулах	60,000,000.0	Орхон аймгийн төвөөс - Сэлэнгэ сум хүртэлх хатуу хучилттай авто замын хээрийн судалгааны ажлын дараах дунд шатны зураг төсвийн хөрөнгө
41	Тэшиг сумын Эгийн голын эргийн бэхэлгээ.	20,000,000.0	АИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн XXV/05 дугаар тогтоолоор нэмэгдсэн. Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дугаар сарын 14-ний өдрийн А/733 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжилт.
42	Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	33,000,000.0	Булган аймгийн Онцгой комиссын 2024 оны 08 дугаар сарын 13-ний өдрийн 48, 2024 оны 09 дугаар сарын 12-ний өдрийн 63 тоот албан бичиг, Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 02-17-01/055/14 тоот дүгнэлт. АИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн XXV/05 дугаар тогтоолоор нэмэгдсэн.
43	Жаргалант зуслангийн уран тогоо хотхон	3,500,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжилт.
44	Жаргалант зуслангийн олимп хотхон	4,000,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжилт.
45	Жаргалант зуслангийн сансар хотхон	3,500,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжилт.
Хэсгийн дүн		172,500,000.0	
<b>Нийт дүн</b>		<b>1,800,000,000.0</b>	<b>Төсөвт өртөг.</b>